



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 5/117

Хэрлэн сум

Б.Оюунтуяаг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтын шинэчилэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 2023 оны 241 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, 489 дүгээр тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дах салбар зөвлөлийн 2023 оны 107 дугаар тогтоол, 2023 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Базаргүрын Оюунтуяа нь төрийн албаны тусгай шалгалтанд тэнцсэн тул Архивын тасгийн Архивын тоо бүртгэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнээр 2023 оны 8 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Оюунтуяагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын
дарга:

Б.Мөнгөнцэцэг:

Архивын тасгийн дарга

Гишүүд:

Г.Тэмүүжин:

Архивын тасгийн Сан хөмрөгийн
эрхлэгч

Ц.Гэрэлтуяа:

Архивын тасгийн Архивч

Д.Мягмарбаатар:

Хууль, эрх зүйн хэлтсийн Жендер,
шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрх
ашгийг хамгаалах гэрээ хариуцсан
мэргэжилтэн,улсын байцаагч

Э.Ариунтунгалаг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нягтлан бодогч

Т.Баяртуяа: Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нярав

3.Б.Оюунтуяагийн үндсэн цалинг ТЗ-8 зэрэглэлээр тогтоон, 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгөөр орон нутагт ажилласны нэмэгдлийн 40 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 11 хувиар тус тус тооцож, олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Архивын тоо бүртгэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Оюунтуяад үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНТУЛГА